

## **Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээр**

### **А.ХЭЛЭЛЦЭЭРИЙН ГОЛ АГУУЛГА:**

Хоёр улсад тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож, тэтгэвэр болон оршуулгын тэтгэмж тогтоох, олгох, тэтгэврийг харилцан шилжүүлэх, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсэн, амаржсаны, ажилгүйдлийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмжүүдийг тогтоолгох боломжтой. Хэрвээ даатгуулагч Монгол улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Польш Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Польш Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.

### **Б. ХЭЛЭЛЦЭЭРТ ХАМААРАХ ТЭТГЭВРИЙН ТӨРӨЛ**

Дараах төрлийн тэтгэврийг Монгол Улс болон БНУУ-ын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

#### **Монгол Улсаас авах тэтгэврийн төрөл:**

- Тэтгэврийн даатгалын сангаас олгох өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- Тэтгэмжийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж;
- Ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох, тэтгэвэр, тэтгэмж.

#### **Бүгд Найрамдах Польш Улсаас авах тэтгэврийн төрөл:**

- Ажилгүйдлийн тэтгэмж (тариачдын нийгмийн даатгал болон нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж);
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж;
- Өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмж;
- Оршуулгын тэтгэмж.

**Монгол Улсын иргэн дараах нөхцлийг хангасан тохиолдолд Бүгд Найрамдах Польш Улсаас өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ:**

1. Бүгд Найрамдах Польш Улсад ажиллаж, шимтгэл төлсөн байх;
  2. Бүгд Найрамдах Польш Улсын хууль тогтоомжид заасан өндөр насны тэтгэврийн нас /эмэгтэй-60, эрэгтэй 65 нас/-нд хүрсэн байх.
  3. Бүгд Найрамдах Польш Улсын хууль тогтоомжоор тогтоосон тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаа /эмэгтэй 20 жил, эрэгтэй 25 жил/-г хангасан байх;
- **Шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаанд Монгол Улсад шимтгэл төлсөн хугацааг оруулан тооцно.**